

Монголбанкны Лондон дахь Төлөөлөгчийн Газрын  
2010 онд хийх ажлын төлөвлөгөө

| Хийх ажлын төлөвлөгөө  | Хугацаа   | Биелэлт   |
|--|---|---|
| <p>1. Олон улсын болон гадаад улсуудын банк, санхүүгийн байгууллагатай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар Үүнд:</p> <p>1.1 Монгол Улсад томоохон банк санхүүгийн байгууллагын салбарыг нээж ажиллуулах бололцоог эрэлхийлэн судлах</p> <p>1.2 Английн арилжааны болон хөрөнгө оруулалтын банкуудтай байгуулсан харилцааг өргөжүүлэх (Сити, Эйч Эс Би Си, Барклес, Ай Эн Жи гэх мэт)</p> <p>2. Монголын банк, санхүүгийн салбарын ажилтан нарыг ТГ газраас өгсөн чиглэлийн дагуу холбогдох сургалтад хамруулах талаар судалгаа хийж, санал боловсруулах, хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх. Үүнд:</p> | <p>ЗГ-н 2009 оны 324-р тогтоолд заасны дагуу</p> <p>Эхний хагас жил</p> | <p>Standard Chartered банктай холбоо тогтоон, банкны санхүү эдийн засгийн талаархи мэдээлэл танилцуулгыг удирдлагад танилцуулан зөвшөөрөл авсны үндсэн дээр удирдлагуудтай нь 3 удаагийн уулзалт хийж, төлөөлөгчийн газар, салбараа Монголд байгуулах асуудлаар зөвлөсөн. Тус банк энэ талаар саналаа удирдагадаа танилцуулан зөвшөөрөл авах ажлаа эхлүүлснээ мэдэгдсэн бөгөөд Монголд удирдах гол ажилтнуудаа явуулж, Монгол улсын зэрэглэлийг дээшлүүлэхэд зөвлөмж өгөх, ОТ төсөлд \$500 сая, Эрдэнэс МЖЛ-д \$30 сая зээл өгөх, төлөөлөгчөө 2011 оны эхний хагас жилд багтаан нээхээ мэдэгдсэн. City, HSBC банкуудтай уулзан, санхүүгийн захын мэдээллийг МБ-ны мэдээлэл хүссэн ажилтнуудад хүргүүлж байна. 4 банкиг МБ, ХБ, ТӨХ, СЯ-ны холбогдох улирлагатай уулзуулах ажлыг УБ-т зохион байгуулав. BNP ОТ-д \$500 сая зээл өгөх, City банк Монголтой ЗГ-н бонд, Хөгжлийн банк, хөгжлийн сангийн чиглэлээр ажиллах талаар хүсэлтээ тавьж, сэтгүүлчдэд ярилцлага өгүүлсэн.</p> <p>Дэлхийн Алтны зөвлөлөөс санхүүжүүлэн Gold as a reserve asset forum for Central bankers and FSA, May 17-19, НК-d МБ-наас хүн оролцуулах саналыг ТГ-т тавьсан. НҮБ-н Сургалт судалгааны институтын E-learning сургалтын талаар судлан танилцуулга</p> |

|   |  |   |
|---|--|---|
| <p>2.1 Германы төв банкинд төлбөр тооцооны чиглэлээр Монголбанкны ажилтнуудыг сургах.</p>                                       | <p>Германы төв банктай хугацааг тохирох</p>    | <p>санал бэлдэж 6 сарын 21-нд удирдлагад хүргүүлснээс гадна БХ, БСТ-д хүргүүлсэн. ДАГ-т аудитын сургалтын, МТГ-т мэдээллийн технологийн захирлуудын уулзалт семинарын талаар мэдээллийг хүргэсэн.</p> <p>Европ, Норвег, Германы төв банкин дээр Хяналтын зөвлөлийн 4 гишүүнийг дадлага хийлгүүлж туршлага судлуулсан. Германы ТБ-наас ТТ авсан.</p>   |
| <p>2.2 Хямралын үеийн мөнгөний бодлого, арга хэрэгслийн талаар хамтран Английн төв банктай сургалт семинар зохион байгуулах</p> | <p>3-р улирал</p>                              | <p>Английн төв банкны сургалт семинарыг УБ-т 8 сарын 2-4нд тус банкны гадаад хамтын ажиллагааны газрын дарга Gill Hammond, зөвлөх Gareth Rule нараар хямралын үеийн мөнгөний бодлого, арга хэмжээ, гарц, бодлогын шинэ арга хэрэгслүүд, ликвидность тооцож төлөвлөх, төв банкны тэнцэл, түүний үр дүн, үйл ажиллагааны хяналт, тулгарч байгаа бэрхшээл, түүнийг даван туулах нь сэдвээр сертификатай сургалтыг МБ, СЯ, МУИС-н 25 хүнд өгүүлсэн.</p>   |
| <p>2.3 Франц, Белгийн Төв банктай хамтран ажиллах талаар яриа хийж, саналаа танилцуулах</p>                                     | <p>2-р улирал<br/>ФТБ-тай хугацааг тохирох</p> | <p>Франц, Бельги, Герман, ЕТБ-тай хамтын ажиллагааны үр дүнг тооцон, цаашид хамтран ажиллах чиглэлээр тохироо уулзалт хийх удирдамжийн төслийг боловруулан төвд хүргүүлсэн бөгөөд Франц, Бельгид уулзалт хийх тушаал, төсөв батлагдаж 7 сарын 7-нд ирснийг үндэслэн Белгийн Төв банктай 10 сард уулзаж, European Institute of Asian study-д EU-Mongolia cooperation илтгэл тавьж снэл хүсэлтээ уламжилсан. Францийн Төв банктай 12 сарын 28-30нд уулзахаар бэлдэж байна. Люксембургийн ЗГ-ын тэтгэлгээр сурах хүний тоонд хязгаарлалт тавихгүйгээр шаардлага хангасан хэдэн ч хүний материал авч байх, сургалтанд МБ-наас гадна СЯ, СЗХ-ноос хамруулж байх болсныг урьдчлан ТГ-т мэдээлж,</p> |
| <p>2.4 Люксембургийн засгийн газрын тэтгэлгээр мастерийн сургалтанд оюутан сургах тоог нэмэгдүүлэх талаар ярилцаж саналаа</p>   | <p>2-р улирал</p>                              | <p>Франц, Бельги, Герман, ЕТБ-тай хамтын ажиллагааны үр дүнг тооцон, цаашид хамтран ажиллах чиглэлээр тохироо уулзалт хийх удирдамжийн төслийг боловруулан төвд хүргүүлсэн бөгөөд Франц, Бельгид уулзалт хийх тушаал, төсөв батлагдаж 7 сарын 7-нд ирснийг үндэслэн Белгийн Төв банктай 10 сард уулзаж, European Institute of Asian study-д EU-Mongolia cooperation илтгэл тавьж снэл хүсэлтээ уламжилсан. Францийн Төв банктай 12 сарын 28-30нд уулзахаар бэлдэж байна. Люксембургийн ЗГ-ын тэтгэлгээр сурах хүний тоонд хязгаарлалт тавихгүйгээр шаардлага хангасан хэдэн ч хүний материал авч байх, сургалтанд МБ-наас гадна СЯ, СЗХ-ноос хамруулж байх болсныг урьдчлан ТГ-т мэдээлж,</p> |

|   |                        |   |
|---|------------------------|---|
| <p>танилцуулах</p>  |                        | <p>Монголбанкны ажилтнуудын материалыг 6 сарын 30-ны дотор ирүүлэхийг ТГ-т мэдэгдсэн боловч материал бүрдэж МБ-наас ирээгүй тул хугацаа сунгаж өгөх хүсэлт тавьж 7 сард багтаан явуулахаар тогтсон. МБСГ-аас 2 ажилтанд 100%-н тэтгэлэгтэй магистерт сурах асуудлыг шийдүүлсэн.</p>   |
| <p>2.5 Люксембургийн сургалтын төвтэй хамтран Улаанбаатар хотод дараах сэдвээр сургалт зохион байгуулах талаар тохиролцох. Үүнд:<br/>- Актив пассивийн удирдлага<br/>- Хөрөнгө оруулалтын банкны бүтээгдхүүн<br/>- Даатгалын бүтээгдэхүүн</p> | <p>1, 2-р улирал</p>   | <p>Актив пассивийн удирдлага сургалт БСТ дээр 4 сард зохиогдсон. 8 сард мөнгө угаалтын эсрэг, банкны зохистой удирдлага, 10 сард олон улсын санхүүгийн хэрэгслүүд, 11 сард салбарын удирдлага, гэсэн 3 сэдэвтэй 20 хүний сургалт хийгдсэн. Даатгалын сургалтын талаар ярилцаж ирэх жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг тавьсан.</p>   |
| <p>3. Монголбанкны нэгдэн орсон олон улсын байгууллагатай идэвхитэй ажиллах</p>   | <p>Эхний хагас жил</p> | <p>ЕСБХБ-ны жилийн тайлангийн хурлын үед Ерөнхийлөгчийн ярих сэдвийн талаар бэлдэж, тус банкны Санхүүгийн байгууллагын газрын захирал Mike Taylor, болон Steffen Pohl, Hue Williams нартай уулзан санхүү банкны салбарт үзүүлэх зээл тусламж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж, €4сая-ийн техникийн туслалцааны тухай ярилцаж дүнг 4сарын 23-нд удирдлагад мэдэгдсэн. Исландийн галт уулын дэлбэрэлттэй холбогдуулан гол төлөөлөгчид, том хөрөнгө оруулагч нар хуралд оролцохгүйг мэдээлсэн. Хуралд оролцох шаардлагагүй гэж удирдлага шийдвэрлэсэн.</p> |
| <p>3.1 ЕСБХБанкны жилийн тайлангийн хуралд оролцох, Монголбанкнаас оролцох төлөөлөгчдийн хамт хурлыг зохион байгуулах</p>   | <p>Эхний хагас жил</p> | <p>ЕСБХБ-ны своп хэлцлийн талаар Aude Pacatte холбогдох ажилтнуудтай уулзаж, репо хийх нь илүү тохиромжтой гэсэн тул гэрээний төслийг төвд хүргүүлээд холбогдох нэмэлт мэдээллийг гаргуулан өгч, хариу шийдвэр хүлээж байна.</p>  |
| <p>3.2 ЕСБХБанкнаас төгрөгөөр бонд гаргуулах ажлын талаар яралцаж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах</p>   | <p>Эхний хагас жил</p> | <p>ОУТТБ-ны удирдах зөвлөлийн даргаар Францын төв банкны Ерөнхийлөгч ажиллаж байгаа тул Францэд хийх уулзалтаар гишүүнчлэлийн асуудлыг</p>  |
| <p>3.3 ОУТТБ-ны гишүүнчлэлийн асуудлыг судлах</p>   |                        |   |

|  |                   |  |
|--|-------------------|--|
| <p>4. Монгол улсын банк санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах судалгаа хийх, банк, санхүүгийн мэдээлэл цуглуулж, тухай бүр Монголбанкинд хүргүүлэх</p>   | <p>Тухай бүр</p>  | <p>тавихаар удирдамжид тусгасан. Гадаадын төв банкуудын хяналт шалгалтын байгууллагуудад хийгдэж байгаа бүтцийн шинэчлэлт өөрчлөлтийн талаар судалж танилцуулга удирдлагад хүргүүлсэн. Юанийн ханшийг илүү уян хатан болгох Хятадын Төв банкны бодлогын шийдвэрийн талаар мэдээлэл хүргэсэн. Алтны үнийн хандлага, HSBC, Mitsue банкуудаас өдөр бүр гаргадаг ханш, валют, алт, хүүгийн болон тухайн өдрийн зах зээлийн онцлог үйл явдлыг агуулсан мэдээг мэдээлэл хүссэн ажилтнуудад шууд өдөр бүр хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Алт,зэсийн үнийн эрсдэлээс хамгаалах эрсдэлийн судалгаа, хеджингийн талаар Barclays банктэй ажиллаж, танилцуулга мэдээллийг МБ-д хүргүүлсэн. Сургалтыг УБ-г ирэх онд хийххэр төлөвлөсөн.</p> |
| <p>4.1 Олон улсын санхүүгийн зах зээл дээрх онцлох гол мэдээллийг Монголбанкны холбогдох ажилтнуудад хүргүүлэх</p>   | <p>Тухай бүр</p>  | <p>Лондонд 4 сард зохион байгуулагдсан Үнэт металлын үйл ажиллагаа эрхэлдэг 200 гаруй компаниудын Гүйцэтгэх захирлуудын зөвлөлгөөнд (Precious Metals CEO Forum) оролцож, Монголын макро эдийн засгийн талаар танилцуулж асуулт хариултанд оролцов</p>  |
| <p>4.2 Монгол улсын эдийн засгын хөгжил, хөрөнгө оруулалт, мөнгө санхүүгийн байдал, монголбанкны үйл ажиллагаа, мөнгөний бодлогын хэрэгжилт, санхүүгийн хөгжил сэдвүүдээр гадаадын хөрөнгө оруулагчдад зориулан уулзалт зохион байгуулах</p> | <p>Тухай бүр</p>  | <p>Лондон хотод 11 сарын 24-25 нд зохион байгуулсан Mongolia Investment Forumд Монголбанкны эдийн засгийн өсөлтөд оруулах үүрэг, мөнгөний бодлогын талаар илтгэл тавьж хэлэлцүүлэгт оролцож, оролцогчдын асуултанд хариулсан.</p>  |
| <p>4.3 Гадаад валютын улсын нөөцийг үр ашигтай зохистой байршуулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, нөөцийн удирдлагыг сайжруулах чиглэлээр судалгаа хийх</p>   | <p>Улирал бүр</p> | <p>Гадаад валютын улсын нөөцийг гадаад менежерээр удирдуулах, Лондонгийн төлөөлөгчийн газрыг өргөжүүлэх замаар еврогийн Fixed Income –д хөрөнгө оруулалт Лондонгоос хийж эхлэх стратеги бодлогыг тодорхойлж, бэлтгэл ажлыг хангуулах, хугацааг</p>   |

|   |                   |  |
|---|-------------------|--|
| <p>4.4 Лондон дахь бусад төв банкуудаас Гадаад валютын нөөцийн болон эрсдлийн удирлагын талаар хийж байгаа ажлыг судалж санал төсөл боловсруулах</p>                | <p>2-р улирал</p> | <p>тодорхойлох, ГВН-ийн програм хангамжийг худалдан авах талаар саналыг боловсруулж удирдлагад хүргүүлсэн. EuroMoney-н 5 сарын Валютын зөвлөлгөөнд оролцож, валютын арилжааны платформ, програм хангамжийн талаархи мэдээллийг ВЭЗГ, МТГ-т хүргүүлсэн. Лондон дахь бусад төв банкуудын 11 төлөөлөгчийн газрын удирдлагатай уулзалт хийж үйл ажиллагааны чиглэл, бүтэц, орон тоо, гадаад валютын нөөцийн удирдлагын зарчим, хөрөнгө оруулалтын чиглэл, төрөл, хугацааны талаар судалж дүнг нэгтгэн Монголбанкинд саналын хамт 6 сарын 13-нд хүргүүлсэн. Дэлхийн банкны ГВН-н удирдлагын хөтөлбөртэй танилцаж, бусад орнууд хэрхэн ашиглаж байгаа мэдээллийг ВЭЗГ, ЭУА-д хүргүүлсэн. Эдийн засаг, бизнесийн бодит байдалд үнэлгээ өгөх аргачлалыг нэвтрүүлэх замаар мөнгөий бодлогын хүү тогтоох шийдвэр гаргалтыг сайжруулах тухай Английн төв банкны туршлагыг судалж Монголд нэвтрүүлэх нэвтрүүлэх санал боловсруулж хүргүүлсэн. ФТБ ны уулзалтын дараа бэлэн болно</p> |
| <p>4.5 Мөнгөний бодлогын хэрэгслүүдийг боловсронгуй болгон талаар Европын орнуудын туршлагыг судалж Монголд нэвтрүүлэх боломжтой эсэх талаар санал боловсруулах</p> | <p>3-р улирал</p> | <p>Багш нарыг санхүү банкны мэдлэгтэй болгох төсөл (Teachers Training Pilot project) боловсруулж ОУСК, ЕСБХБ, Люксембург, Шинэ Зеланд, Английн олон нийтийн санхүүгийн боловсрол олгох газарт ТТ хүсч хүргүүлсэн. Төсөлд Англи, АНУ-ын туршлагаас судалж харьцуулсан дүгнэлт хийж оруулсан. Төслийн дүн ₮70,0 сая, тооцооны хамт 11 хуудас.</p>  |
| <p>4.6 Санхүүгийн хямралын эсрэг авч хэрэгжүүлж байгаа туршлагаас судалж танилцуулга бэлдэх</p>   | <p>4-р улирал</p> | <p>Түүвэр судалгааны загварыг гаргаж ВЭЗГ-тай тохирсон. төсвийг ТГ-аас</p>   |
| <p>4.7 Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар бусад Төв банкуудын авч байгаа арга хэмжээний туршлагыг судалж танилцуулга бэлдэх</p>                  | <p>4-р улирал</p> | <p>Түүвэр судалгааны загварыг гаргаж ВЭЗГ-тай тохирсон. төсвийг ТГ-аас</p>   |
| <p>4.8 Англид амьдарч байгаа Монголчуудын дунд ар гэртээ</p>  | <p>4-р улирал</p> | <p>Түүвэр судалгааны загварыг гаргаж ВЭЗГ-тай тохирсон. төсвийг ТГ-аас</p>   |

|   |                        |  |
|---|------------------------|--|
| <p>шилжүүлж буй мөнгөн гуйвуулгын талаар түүвэр судолгаа явуулж, нэгдсэн дүнг гарган судалгааны материалын хамт ВЭЗГ-г хүргүүлж, Монгол Улсын төлбөрийг тэнцэлт тусгуулах</p>                               |                        | <p>баталж ирүүлэнгүүт эхэлнэ</p>   |
| <p>5. Монгол улсын банк санхүүгийн үйл ажиллагааг гадаад улсад танилцуулах түнш байгууллагуудтай тогтоосон холбоог бэхжүүлэх, шинэ харилцаатай болоход дэмжлэг, туслалцаа үзүүлэх</p>                       | <p>Эхний хагас жил</p> | <p>Лондонгийн хөрөнгийн бирж дээр Монголын уул уурхайн санхүүжилт сэдвээр зохион байгуулагдсан (Mongolia Mining Finance Day at London Stock Exchange) хуралд оролцож, ЕСБХБ-ны банк бус санхүүгийн байгууллага хариуцсан ахлах банкир Joon Parkийг Монголын талын төлөөлөгчид болох ТӨХ-ны дарга Сугар, Хөрөнгийн биржийн орлогч захирал Алтай нартай уулзуулан хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд техникийн туслалцаа олгуулах боломжийн талаар урьдчилсан тохиролцоо хийсэн. Монголын талаас албан есны хүсэлт гаргахад зөвлөгөө өгүүлсэн. Удирдлагын санхүүжилтэнд тус банкнаас ТТ авах боломж нөхцөлийн талаар ЭСЯ, ХБ, ТӨХ-д мэдэгдсэн .<br/>BoAML FX, BoNYMellon Global Custody-н талаар валютын нөөцийн удирдлагын ажилтнуудтай хамтран ажиллах талаар уулзуулсан.</p> |
| <p>5.1 Английн төв банк болон Лондон бусад төв банкуудын төлөөлөгч нарын уулзалтанд байнга оролцож өөрийн орны туршлага мэдээллийг танилцуулж, бусад орнуудын туршлагыг нэгтгэн Монголбанкинд хүргүүлэх</p> | <p>Тухай бүр</p>       | <p>Английн Төв банкнаас зохион байгуулсан Зохистой удирдлага, тулгарч байгаа бэрхшээл, ирээдүйн хандлага 4 хоногийн семинарт ажиглагчаар оролцсон.<br/>Японы Төв банкны төлөөлөгчийн газрын хүлээн авалтанд оролцож, банк санхүүгийн талаар мэдээлэл солилцож Английн Санхүүгийн зохицуулах албаны хүмүүстэй танилцсан.<br/>Төлөөлөгчийн газрын 2011 оны төсөв, төлөлөгөөг бэлдэж хүргүүлсэн.<br/>Жилийн тайланд оруулах тайлангийн төслийг бэлдэж оны эцэст хүргүүлэхээр бэлдэж байна.</p>  |
| <p>6. Бусад</p> <p>6.1 2010 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж Тамгын газарт хүргүүлэх</p> <p>6.2 Төлөөлөгчийн үйл ажиллагааны</p>   | <p>4-р улирал</p>      | <p>Төлөөлөгчийн санхүүгийн тайлангийн нэмэлт материал ёслолын ажиллагааны тайланг бүрдүүлж электрон шуудангаар явуулсан бөгөөд эхний хагас жилийн</p>  |

|   |                        |  |
|---|------------------------|--|
| <p>тайланг бэлдэж, МБСГазарт жилийн тайланд оруулахаар хүргүүлэх</p>                              | <p>4-р улирал</p>      | <p>үйл ажиллагааны зардлын урьдчилгаа 7 сарын 9-нд шилжин ирсэн тул эхний хагас жилийн санхүүгийн баримтуудыг Монголд очихдоо өгсөн.</p>   |
| <p>6.3 Төлөөлөгчийн санхүүгийн тайланг гаргаж ТГ, ТТБүртгэлийн газарт хүргүүлэх</p>               | <p>Хагас жил тутам</p> | <p>ОУТТБ-аас гаргасан Төв банкны зохистой удирдлага болон санхүүгийн тогтвортой байдал ном, Standard Chartered банк, Dexia, BNP pariba</p>   |
| <p>6.4 Цуглуулсан мэдээлэл, судалгаа материалуудыг Монголбанкны холбогдох газруудад хүргүүлэх</p> | <p>Тухай бүр</p>       | <p>банкуудын танилцуулга, Голландын хөрөнгө оруулалтын корпорациас зохион байгуулсан семинарт оролцож хөрөнгө оруулалтын талаар баримталж байгаа чиглэл хандалгын талаархи материалыг төвд хүргүүлсэн.</p> |

**Төлөвлөгөөнөөс гадуурхи бусад хийсэн ажлуудын тухай**

1. 7 сарын 9-нд ЭСЯ-наас Ардын хувьсгалын 89 жилийн ойн баярын арга хэмжээнд оролцож, харилцагч банкуудын 25 төлөөлөгчийг урин оролцуулав.
2. 5 сарын 2-нд ЭСЯ болон Монголчуудын холбооноос зохион байгуулсан Монголын хөгжилд сэдэвт уулзалт арга хэмжээнд оролцож судлаач, эрдэмтэн залуучуудад Монголбанкны судалгааны талаар мэдээлэл өгсөн.
3. ЕСБХБ-ны Монголыг хариуцсан эдийн засагч өөрчлөгдөж, Alexandr Plekhanov болсонтой холбогдуулан Монголд Банкуудын Холбоон дээр байгалийн баялагын

хараалаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар банкуудын ажилтнуудад лекц уншуулах, ЗМС-ийн чиглэлээр хамтран ажиллах бололцоо, ХШХ-н захирал Батбаатартай зээлийн мэдээллийн сан, санхүүгийн тогтвортой байдал, МБ-ны ВЭЗГ-ын удирдлагатай хамтран ажиллах бололцоо, гадаад эдийн засгийн талаар мэдээлэл солилцох хамтран ажиллах талаар танилцах уулзалтуудыг хийлгүүлсэн.

4. Австрали, Турк, Италийн төв банкны Лондон дахь төлөөлөгчийн газруудаар дамжуулан эдгээр банкуудын гадаад хамтын ажиллагааны газрынхантай холбоо тогтоон ажиллаж байна. Туркийн төв банкны Ерөнхийлөгчид МБ-ны Ерөнхийлөгчийн албан захидал илгээх саналыг ТГ-т явуулсан. Үүний үр дүнд хамтын ажиллагааны асуудлаар ТГ-н захирал хэлцэл хийхээр явсан. Австралийн төв банкнаас валютын нөөцийн удирдлагын туршлагыг судалж мэдээллийг ВЭЗГ, ЭУА-нд хүргүүлсэн бөгөөд тус банкнаас газар дээр нь туршлага судалж дадлага хийх талаар хүсэлт тавихад боломжтой гэж мэдэгдсэн бөгөөд манай талаас хэдэн хүн хэзээ, ямар хугацаагаар, ямар сэдвээр суралцах хүсэлтэй байгаа талаар мэдээлэхийг хүссэнийг мөн төвд уламжлан хариуг хүргүүлсэн. 12 сард 2 зөвлөх эксперт ирж ЭУА, ВЭЗГ-т ажиллаж зөвлөгөө өгсөн.
5. Төв банкны хэвлэлийн байгууллага, Institutional Investor хэвлэлийн байгууллагуудтай тэдгээрийн хүсэлтийн дагуу уулзаж, Монголын эдийн засгийн төлөв байдал, Төв банкнаас авч хэрэгжүүлж байгаа бодлогын талаар танилцуулсан бөгөөд санхүүгийн хямрал, мөн төлөвлөгдөгдөөгүй зардал тул төлбөртэйгээр Монголыг сурталчлах ажлыг одоогоор хийх боломжгүйг мэдэгдсэн. Bloomberg-ярилцлага өгсөн.
6. Монголбанкны гадаад дахь төлөөлөгчийн газрын журмыг өөрчлөн шинэчилж, төсөл танилцуулгыг удирдлагад хүргүүлсэн. 33 хуралд хэлэлцүүлэн Ерөнхийлөгчөөр 2010 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 665 тоот тушаалаар батлуулсан. Журмыг орчуулан Английн банкинд данс нээлгүүлэх бэлтгэлийг хангаж байна.
7. Их Британи дахь ЭСЯ-дын эдийн засаг санхүүгийн зөвлөхүүдийн 5,6 сарын арга хэмжээнд оролцож, Economic Intelligence Unit- ээс тавьсан дэлхий хаашаа чиглэж байна илтгэл хэлэлцүүлэг, Israeli opportunity 2010 арга хэмжээнд тус тус оролцож Израйлийн Төв банкны Ерөнхийлөгч Stanley Fischer-тэй танилцаж МБ-тай хамтран ажиллах асуудлыг тавьсан.
8. ТДЕ-д ОУТТБ-ны жилийн тайлангийн хуралд оролцоход зориулан гадаадын төв банкуудтай хийж байгаа хамтын ажиллагааны талаархи товч мэдээллийг саналын хамт бэлдэж өгсөн.
9. Global Sovereign Funds Roundtable арга хэмжээнд оролцож Хүний хөгжлийн сангийн талаар илтгэл тавьж асуулт хариултанд оролцов.

10. Санхүүгийн мэдээллийн албаны хүсэлтээр Английн Онц ноцтой, зохион байгуулалттай гэмт хэргийн агентлагийн гадаад харилцаа хариуцсан John Blank-тэй уулзалт зохион байгуулж, хамтын ажиллагааны талаар санал солилцсон бөгөөд одоогоор тус газарт бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж байгаа тул түүний дараагаар дахин уулзахаар тохирсон. Их Британи нь Мөнгө угаахтай тэмцэх Олон улсын байгууллагын гишүүн тул тус байгууллагын ажлын хүрээнд гишүүн бүх байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажилладаг болохыг мэдээлсэн
11. АХБ-ны техник туслалцаатайгаар Монголбанкинд Mobile banking-ны эрх зүйн шинэчлэлт хийх нөхцөлийг бүрдүүлэх \$400,000 төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
12. Төлөөлөгчийн газрын байрны үйлчилгээний төлбөртэй холбоотой маргааныг шийдвэрлэх үүргийг ТГ-аас өгсний дагуу гүйлгээ төлбөрүүдийн талаархи мэдээллийг өр барагдуулах байгууллагад гарган өгч шийдвэрлүүлсэн.
13. Их Британийн эдийн засаг, байгаль орчны төвөөс Монголын ус цаг уурын нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж байгаа төслийн эхний урьдчилгаа төлбөр хугацаандаа хийгдэхгүй цаг алдаж байгаа тухай ирүүлсэн гомдлыг судалж, Хадгаламжийн банктэй холбоо барьж зохих журмын дагуу шийдвэрлүүлсэн.
14. State Street Global Advisors Limited –ээс зохион байгуулсан төрийн байгууллагуудад зориулсан уулзалтанд оролцов.
15. Улс тунхагласны арга хэмжээ, Монголчуудын соёлын төвийн арга хэмжээ, уулзалтанд оролцлоо.
16. Английн Санхүүгийн төв City-ийн амбан захирагч Лондонд суугаа гадаадын ЭСЯ, эдийн засгийн төв байгууллагуудын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтанд оролцож, ажлаа танилцуулан Монгол улсын Ерөнхий сайдын айлчлал хийхтэй холбогдуулан Английн банк санхүүгийнхэнтэй Монголынхыг уулзуулах, 2012 онд Амбан захирагчийг банк санхүүгийн төлөөлөгч нартайгаа Монголд айлчлуулах саналыг тавьж энэ тухай ЭСЯ-д мэдээлсэн.
17. Лондонд SWIFT-ийн сургалтанд ирсэн Нямжав, Английн төв банкны сургалтанд ирсэн ХШГ-н Лут-Очир, Лидсийн их сургуульд мастерийн сургалтанд ирсэн Энэрэлт нарын нарын хүсэлтээр Лондонд зорчих, байх хугацаанд шаардлагатай мэдээллээр хангах, сургууль холбогдох байгууллагад шаардлагатай мэдээллийг дамжуулж өгөх, шуурхай холбоо тогтоох зэрэгт туслалцаа үзүүлсэн
18. Хөгжлийн банкны ТУЗ-ын хуралд биеэр 3 удаа оролцов.

